**МОНГОЛ УЛС**
**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН**
**ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2023 оны 07 сарын 17 өдөр Дугаар А/423 Есөнбулаг

# Дуудлага худалдаа зохион байгуулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.1 дэх заалт, 29 дүгээр зүйлийн 29.1, 29.[1]1 дэх хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.6.1 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.1.23 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тусгай зориулалтаар агнуурын амьтныг агнах, барих тусгай зөвшөөрөл олгох дуудлага худалдаа зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | | |
|---|---|---|
| Ажлын хэсгийн дарга: | Л.Хаш-Эрдэнэ | (Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга) |
| Гишүүд: | Г.Болдбаатар | (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч) |
| | Д.Батмагнай | (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн албаны дарга) |
| | Ж.Билэгсайхан | (Орон нутгийн өмчийн газрын өмчийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн) |
| Нарийн бичгийн дарга: | Г.Олонбаатар | (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын амьтны асуудал, мэдээллийн сан, мэдээллийн технологийн асуудал хариуцсан мэргэжилтэн) |

2.Тусгай зориулалтаар агнуурын амьтныг агнах, барих тусгай зөвшөөрлийн дуудлага худалдаа зохион байгуулах удирдамжийг батлуулан, дуудлага худалдааг хууль журамд нийцүүлэн зохион байгуулж, тайлагнаж ажиллахыг ажлын хэсэг (Л.Хаш-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ОРЛОГЧ Г.ЧИНБАТ

C:/ My Documents A-4 doc

0001750449

2022 10 06

0201160229